

ОЛОН НИЙТЭЭР ХЭЛЭЛЦҮҮЛЭХ ТӨСӨЛ

БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ, ТҮҮНД ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн дагуу банкинд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоох, түүнийг мөрдүүлэх харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Банк дараах зохистой харьцааг хангаж ажиллана. Үүнд:
 - 1.2.1. Өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцаа;
 - 1.2.2. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа;
 - 1.2.3. Гадаад валютын ханшийн эрсдэлийн зохистой харьцаа;
 - 1.2.4. Төвлөрлийн эрсдэлийн зохистой харьцаа;
- 1.3. Банк энэ журмын 1.2-т заасан зохистой харьцааны үзүүлэлтийг үнэн зөв тооцож, түүнд үнэлэлт, дүгнэлт хийх замаар үйл ажиллагаандаа учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авна.
- 1.4. Монголбанк банкны үйл ажиллагааны цар хүрээ, онцлог, эрсдэлийг харгалзан энэхүү журмын 1.2-т зааснаас гадна нэмэлт зохистой харьцааг тогтоон, мөрдүүлж болно.

ХОЁР. ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭНИЙ ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

- 2.1. Банкны эрсдэл даах чадварыг Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д заасан өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээр үнэлэх бөгөөд дараах зохистой харьцааг тогтооно. Үүнд:
 - 2.1.1. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа;
 - 2.1.2. Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа;
 - 2.1.3. Хөшүүргийн харьцаа.
- 2.2. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг энэ журмын 2.7-д заасан нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 2.9-д заасны дагуу тохируулан, 2.14-т тодорхойлсон эрсдэлээр жигнэсэн активт харьцуулан тооцно.
- 2.3. Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг энэ журмын 2.6-д заасан өөрийн хөрөнгийг 2.9-д заасны дагуу тохируулан, 2.14-т тодорхойлсон эрсдэлээр жигнэсэн активт харьцуулан тооцно.
- 2.4. Хөшүүргийн харьцааг энэ журмын 2.7-д заасан нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийг 2.9-д заасны дагуу тохируулан, арилжааны авлага, өглөгийн зөрүүгээр цэвэршүүлсэн нийт актив болон цэвэр хүлээж болох үүргийн¹ 50 хувийн нийлбэртэй харьцуулан тооцно.
- 2.5. Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааны доод хэмжээ 9 хувь, Өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын

¹ тэнцлийн гадуур бүртгэлтэй, хүлээж болзошгүй үүргийн нийт дүнгээс тэдгээрийн үүргийг хангуулах зорилгоор бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэрийн нийлбэрийг хассаныг

зохистой харьцааны доод хэмжээ 12 хувь, Хөшүүргийн харьцааны доод хэмжээ 5 хувь байна.

2.6. Банкны өөрийн хөрөнгө нь нэг болон хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн нийлбэр байна.

2.7. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- 2.7.1. Энгийн хувьцаа;
- 2.7.2. Энгийн хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал;
- 2.7.3. Хуримтлагдсан ашиг, алдагдал;
- 2.7.4. Нөөцийн сан.

2.8. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- 2.8.1. Давуу эрхийн хувьцаа;
- 2.8.2. Давуу эрхийн хувьцаанаас нэмж төлөгдсөн капитал;
- 2.8.3. Хувьцаанд хөрвөх эх үүсвэр;
- 2.8.4. Хоёрдогч өглөг.

2.9. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд оруулж тооцох давуу эрхийн хувьцаа дараах шаардлагыг хангасан байх бөгөөд эдгээрийг гэрээнд тодорхой тусгасан байна. Үүнд:

- 2.9.1. Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд хугацаанаас өмнө буцаан худалдаж авах нөхцөлгүй;
- 2.9.2. Банк заавал ногдол ашиг, хүү, өгөөж төлөх үүрэггүй;
- 2.9.3. Энэ журмын 3.7.2, 3.8.4 дахь заалтууд тусгасан хязгаарлалт хэрэгжих боломжтой;

2.10. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд оруулж тооцох хувьцаанд хөрвөх эх үүсвэр дараах шаардлагыг хангасан байх бөгөөд эдгээрийг гэрээнд тодорхой тусгасан байна. Үүнд:

- 2.10.1. Энэ журмын 3.7.1, 3.8.4 дахь заалтуудад тусгасан хязгаарлалт хэрэгжих боломжтой;
- 2.10.2. Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эвсэл өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 20 хувиар алдагдах тохиолдолд шууд энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй;
- 2.10.3. Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд хугацаанаас нь өмнө төлөхгүй;
- 2.10.4. Хөрөнгө оруулагч, түүний эх үүсвэр нь банкны зөвшөөрлийн журмаар тавигдаж буй шаардлагыг хангасан;
- 2.10.5. Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд хөрөнгө оруулагчийг солихгүй;

2.11. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд оруулж тооцох хоёрдогч өглөг дараах шаардлагыг хангасан байх бөгөөд эдгээрийг гэрээнд тодорхой тусгасан байна. Үүнд:

- 2.11.1. 5 ба түүний дээш жилийн гэрээний хугацаатай, хугацааны эцэст эх үүсвэр байршуулагчийн шийдвэрт үндэслэн энгийн хувьцаанд хөрвөж болох;
- 2.11.2. Хугацааны турш үндсэн төлбөрийн эргэн төлөлт хийхгүй;
- 2.11.3. Энэ журмын 3.7.1, 3.8.4 дахь заалтууд заалтуудад тусгасан хязгаарлалт хэрэгжих боломжтой;

- 2.11.4. Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө эвсэл өөрийн хөрөнгийн зохистой харьцаа 40 хувиар алдагдах тохиолдолд шууд энгийн хувьцаанд хөрвөх нөхцөлтэй;
- 2.11.5. Монголбанкнаас урьдчилан зөвшөөрөл авснаас бусад тохиолдолд хугацаанаас нь өмнө буцаан төлөхгүй;
- 2.11.6. Хөрөнгө оруулагч, түүний эх үүсвэр нь банкны зөвшөөрлийн журмаар тавигдаж буй шаардлагыг хангасан байна.

2.12. Банкны өөрийн хөрөнгөд дараах тохируулгыг хийнэ. Үүнд:

- 2.12.1. Биет бус хөрөнгийн гүүдвил, програм хангамж, хойшлогдсон татварын авлагыг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасна;
- 2.12.2. Халаасны хувьцаагаар тохируулга хийнэ;
- 2.12.3. Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлээр тогтоогдсон хязгаарлалтыг давсан хэсгийг 75 хувийг нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс, үлдсэн 25 хувийг хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөөс хасна;
- 2.12.4. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн дүнгийн 50 хувиас илүүгүй байна;
- 2.12.5. Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгөд оруулан тооцох хувьцаанд хөрвөх эх үүсвэр болон хоёрдогч өглөгийн нийлбэр нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтрэхгүй.

2.13. Монголбанкны шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдалтай холбоотой залруулгын гүйлгээг зохих дансанд хийж өөрийн хөрөнгийн бодит дүнг гаргана.

2.14. Банкны эрсдэлээр жигнэсэн актив дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

- 2.14.1. Зээлийн эрсдэлээр жигнэсэн актив;
- 2.14.2. Гадаад валютын ханшийн эрсдэлээр жигнэсэн актив;
- 2.14.3. Үйл ажиллагааны эрсдэлээр жигнэсэн актив.

2.15. Зээлийн эрсдэлээр жигнэсэн активын дүнг тооцоходоо тэнцлийн актив, тэнцлийн гадуурх хүлээж болзошгүй үүргийн дүнг энэ журмын 1 дүгээр хавсралтад тусгасан эрсдэлийн хувиар үржүүлж гаргах бөгөөд дараах зарчмыг баримтална. Үүнд:

- 2.15.1. Санхүүгийн деривативын зээлтэй адилтган тооцох өртгийг энэ журмын 9 дүгээр хавсралтад заасан аргачлалын дагуу тооцно. Тооцоогүй тохиолдолд деривативын авлагыг ханшийн эрсдэлтэй зээлтэй адилтган үзэж эрсдэлээр жигнэнэ;
- 2.15.2. Актив энэ журмын 1 дүгээр хавсралтад тусгасан нэгээс олон ангилд хамаарч байгаа бол хамгийн өндөр эрсдэлийн жинтэй ангилалд хамааруулна;
- 2.15.3. Стандарт энд Пурс (Standard & Poors), Муудиз (Moody's), Фич (Fitch) байгууллагаас тогтоосон зээлжих суурь зэрэглэлийг ашиглан гадаадын банкнаас авах авлагын эрсдэлийн хувь хэмжээ болон гадаадын банкны батлан даалтаар баталгаажсан зээлийн эрсдэлийн хувь хэмжээг дараах хүснэгтийг үндэслэн тогтооно.

Стандарт энд Пурс	AAA / AA-	A+ / A-	BBB+ / BBB-	BB+ / B-	B- бага	Рейтинггүй банк
Фич						
Муудиз	Aaa/Aa3	A1/A3	Baa1/Baa3	Ba1/B3	B- бага	

3 сараас дээш хугацаатай авлага	20%	50%	50%	100%	150%	100%
3 сараас доош хугацаатай авлага	20%	20%	50%	100%	150%	100%

- 2.15.4. Энэ журмын 2.15.3-т заасан 2 болон түүнээс дээш зэрэглэл тогтоох байгууллагаас зээлжих зэрэглэл тогтоолгосон гадаадын банкнаас авах авлага болон түүний батлан даалтаар баталгаажсан зээлийн эрсдэлийн хувь хэмжээг тооцохдоо хамгийн доод зэрэглэлийг ашиглана.
- 2.16. Эрсдэлээр жигнэх тэнцлийн болон тэнцлийн гадуурх активын үлдэгдэлд дараах тохируулгыг хийнэ. Үүнд:
- 2.16.1. Актив нь Монгол Улсын Засгийн газрын баталгаа, олон улсын зээлжих зэрэглэлийг тогтоогч байгууллагын “А”-аас доошгүй үнэлгээ бүхий санхүүгийн байгууллагаас гаргасан баталгаа, батлан даалт, тэдгээртэй эрсдэл хуваах хэлцлээр баталгаажсан бол харгалзах дүнгээр цэвэршүүлнэ;
- 2.16.2. Актив нь Дэлхийн банк (*Worldbank*), Олон улсын санхүүгийн корпораци (*IFC*), Европын сэргээн босголт, хөгжлийн банк (*EBRD*), Азийн хөгжлийн банк (*ADB*), Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк (*AIB*), Даян дэлхийн байгаль орчны сан (*GEF*), Ногоон уур амьсгалын сан (*GCF*)-гаас гаргасан баталгаа, батлан даалт, тэдгээртэй эрсдэл хуваах хэлцлээр баталгаажсан бол харгалзах дүнгээр цэвэршүүлнэ;
- 2.16.3. Актив нь дотоодын банк, Монгол Улсын Хөгжлийн банктэй эрсдэл хуваах нөхцөлтэй (*syndicated loans гэх мэт*) бол харгалзах дүнгээр тухайн банкны активыг цэвэршүүлж, эрсдэл хуваагч банкны активыг нэмэгдүүлнэ;
- 2.16.4. Тухайн активд зориулж тусгайлан байгуулсан сангаар цэвэршүүлнэ;
- 2.16.5. Актив нь үл маргах журмаар цэвэршүүлэх (*netting arrangement*) нөхцөлтэй тухайн банкинд байршуулсан санхүүгийн эх үүсвэрээр баталгаажсан бол харгалзах дүнгээр цэвэршүүлнэ;
- 2.16.6. Активын барьцаа нь Засгийн газрын үнэт цаас, Төв банкны үнэт цаас бол Төв банкнаас санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгийн жагсаалтад тусгасан хэлбэр, хугацаанд харгалзах хувиар хямдуулсан үнэлгээгээр цэвэршүүлнэ.
- 2.17. Гадаад валютын ханшийн эрсдэлээр жигнэсэн активыг энэ журмын 5.3-т тусгасан нийт нээлттэй позицгийн дүнгээр тодорхойлно.
- 2.18. Үйл ажиллагааны эрсдэлээр жигнэсэн активыг тухайн банкны сүүлийн гурван жилийн нийт орлогын дунжийн 1 хувийг түүнд тогтоосон өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааны доод хэмжээний урвуугаар үржүүлэн тодорхойлно.
- 2.19. Банкны эрсдэл даах чадвар зах зээлийн эрсдэлд хэт мэтрэмтгий гэж Монголбанк үзвэл нэмэлт зах зээлийн эрсдэлээр жигнэсэн актив тооцох тусгай аргачлалыг тухайн банкинд тогтоон, мөрдүүлж болно.

ГУРАВ. БАНКНЫ ЭРСДЭЛ ДААХ ЧАДВАРЫГ ХАМГААЛАХ НӨӨЦ

- 3.1. Сүүлийн 6 сарын турш банкны системийн нийт активын 5 хувиас дээш хувийг эзэлж байгаа банкныг системд нөлөө бүхий банк гэж үзэх бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар тогтооно.
- 3.2. Банкны эрсдэл даах чадварыг хамгаалах зориулттай бүхий нөөц интервалыг түүний

нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцааны доод хэмжээн дээр нэмж тогтооно.

3.3. Нөөц интервал нь суурь болон тусгай хэсгийн нийлбэрээс бүрдэнэ.

3.4. Суурь хэсэг бүх банкинд хамаарах ба 2 нэгж хувь байна. Тусгай хэсэг нь суурь хэсэг дээр нэмэгдэх ба зөвхөн системийн нөлөө бүхий банкинд хамаарна².

3.5. Тусгай хэсэг нь тогтмол болон хувьсах бүрэлдэхүүнтэй байна. Тогтмол хэсэг нь 1 нэгж хувь байх бол хувьсах хэсгийг дараах хүснэгтийн дагуу тооцно.

№	Үзүүлэлтүүд	Тайлбар	Шаардлага	
1	Системийн нийт активд эзлэх хувь	Өнгөрсөн жилийн эцсийн үзүүлэлтээр	15%-аас бага бол 0%	15%-аас их бол 0.5%
2	Нийт банк хоорондын дамжуулсан гүйлгээний тоонд эзлэх хувь	Өнгөрсөн жилд хийгдсэн нийт тоогоор	10%-аас бага бол 0%	10%-аас их бол 0.25%
3	Нийт иргэдийн зээлд эзлэх хувь, нийт байгууллагын зээлд эзлэх хувь хоёрын хамгийн их	Өнгөрсөн жилийн эцсийн үзүүлэлтээр	10%-аас бага бол 0%	10%-аас их бол 0.25%

3.6. Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцаа нь зохистой харьцааны доод хэмжээ болон тухайн банкинд тогтоосон нөөц интервалын нийлбэрээс бага бол нөөц алдагдсан гэж үзнэ.

3.7. Нөөц 50 хүртэл хувиар алдагдсан тохиолдолд³ банкны үйл ажиллагааны орлого, ашиг, нөөцийг түүний эрсдэл даах чадварыг хамгаалах, цаашид муудахаас сэргийлэх зорилгоор дараах хязгаарлалтыг хийнэ. Үүнд:

3.7.1. Энгийн хувьцаанд ноогдол ашиг хуваарлахыг хориглоно;

3.7.2. Өөрийн хөрөнгийн бүрдэлхүүнд хамааруулсан хувьцаанд хөрвөх нөхцөлтэй эх үүсвэр болон хоёрдогч өглөгт хуваарын дагуу эргэн төлөгдөх төлбөрийн 50-иас илүү хувийг төлөхийг хориглоно;

3.7.3. Давуу эрхийн хувьцаанд хуваарийн дагуу эргэн төлөгдөх төлбөрийн 50-иас илүү хувийг төлөхийг хориглоно;

3.7.4. Төлөөлөн удирдах болон гүйцэтгэх удирдлагад олгох урамшуулал, бусад төрлийн гүйцэтгэлд суурилсан нэмэгдлийн 50-иас илүү хувийг төлөхийг хориглоно.

3.8. Тухайн банкинд тогтоосон интервал 50 ба түүнээс илүү хувиар алдагдсан тохиолдолд⁴ банкны үйл ажиллагааны орлого, ашиг, нөөцийг түүний эрсдэл даах чадварыг нэмэгдүүлэх, төлбөрийн чадварыг хадгалах зорилгоор дараах хязгаарлалтыг хийнэ. Үүнд:

3.8.1. Төлөөлөн удирдах болон гүйцэтгэх удирдлагын цалин, түүнтэй адилтгах бусад хөнгөлөлт, нэмэгдлийг өсгөхийг хориглоно;

3.8.2. Хувьцаа буцаан худалдаж авахыг хориглоно;

3.8.3. Энгийн хувьцаанд ноогдол ашиг хуваарлахыг хориглоно;

² Системийн нөлөө бүхий банкны хувьд $9\%+2\%+[1\%;2\%]$. Бусад банкны хувьд $9+2\%$.

³ Харьцааны биелэлт 10.1 хувь, харьцааны доод хэмжээ болон нөөц интервалын нийлбэр нь $9+2\%=11$ хувь байг. Алдагдлын хувь нь $=(11-10.1)/2=0.45$ буюу нөөцийн алдагдал 45 хувь байна.

⁴ Харьцааны биелэлт 9.9 хувь, харьцааны доод хэмжээ болон нөөц интервалын нийлбэр нь $9+2\%=11$ хувь байг. Алдагдлын хувь нь $=(11-9.9)/2=0.55$ буюу нөөцийн алдагдал 55 хувь байна.

- 3.8.4. Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй эх үүсвэр, хоёрдогч өглөг, давуу эрхийн хувьцаатай холбоотой аливаа төлөлт хийхийг хориглоно;
- 3.8.5. Төлөөлөх болон гүйцэтгэх удирдлагад олгох урамшуулал, бусад төрлийн гүйцэтгэлд суурилсан аливаа нэмэгдэл олгохыг хориглоно.
- 3.9. Банкны нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа алдагдсан бол дараах арга хэмжээг авна. Үүнд:
- 3.9.1. Энэ журмын 3.8.1-3.8.5 дахь арга хэмжээ;
- 3.9.2. Төлөөлөн удирдах болон гүйцэтгэх удирдлагад цалин, хөлс, түүнтэй адилтгах бусад нэмэгдэл, дэмжлэг, хандив олгохыг хориглоно;
- 3.9.3. Банкны удирдлага хувьцаанд хөрвөх нөхцөлтэй эх үүсвэр (хоёрдогч өглөг)-ийг энгийн хувьцаанд хөрвөх арга хэмжээний бэлтгэлийг Компаний тухай хууль, банкны дүрэм, бусад эрх зүйн актад нийцүүлэн яаралтай гүйцэтгэж, үр дүнг Монгобанкинд мэдээлнэ.
- 3.10. Хувьцаанд хөрвөх нөхцөлтэй эх үүсвэр (хоёрдогч өглөг)-ийг хувьцаанд хөрвүүлэхэд дараах дарааллыг баримтлана. Үүнд:
- 3.10.1. Хувь нийлүүлэгч, холбогдох этгээдийн хувьцаанд эх үүсвэр (хоёрдогч өглөг)-ийг бүхэлд нь;
- 3.10.2. Энэ журмын 3.10.1 дахь хэсэгт тусгасан арга хэмжээ авсны дараа нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа хангагдаагүй бол бусад хөрөнгө оруулагчийн эх үүсвэр (хоёрдогч өглөг)-ийг хэсэгчлэн, эсвэл бүхэлд.

ДӨРӨВ. ТӨЛБӨР ТҮРГЭН ГҮЙЦЭТГЭХ ЧАДВАРЫН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

- 4.1. Харилцагчийн анхны шаардлагаар төлбөр гүйцэтгэх банкны чадварыг хангах, банкны актив, пассивын эргэн төлөгдөх хугацаа, бүтцийг тэнцвэртэй байлгах зорилгоор Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааг тогтооно.
- 4.2. Энэ журмын 3.1-д тусгасан зохистой харьцааны доод хэмжээ 25 хувь байна.
- 4.3. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг энэ журмын 4.4-д заасны дагуу тохируулсан түргэн борлогдох хөрөнгийг 4.6-д заасны дагуу тохируулсан бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгөд харьцуулан тооцно. Биелэлтийг энэ журмын 2 дугаар хавсралтын дагуу долоо хоног болон сар бүр ирүүлнэ.
- 4.4. Түргэн борлогдох хөрөнгөд бэлэн мөнгө, Монголбанкинд байршуулсан хөрөнгө, банк хоорондын захаас авах цэвэр авлага, Стандарт энд Пурс (Standard & Poors), Муудиз (Moody's), Фич (Fitch) байгууллагаас тогтоосон "А"-аас доошгүй үнэлгээ бүхий гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хөрөнгө, сорьцоор баталгаажсан алтан, мөнгөн гулдмай, Төв банкны үнэт цаас, Засгийн газрын үнэт цаас, Засгийн газрын баталгаатай үнэт цаасны дүнг нэмж тодорхойлох бөгөөд дараах тохируулгуудыг гүйцэтгэнэ. Үүнд:
- 4.4.1. Клирингийн дамжуулалтын саатлын дансдын үлдэгдлийг хасна;
- 4.4.2. Аливаа санхүүгийн хэлцлийн үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцаалсан, байршуулсан түргэн борлогдох хөрөнгийг хасна;
- 4.4.3. Гэрээний үндсэн дээр хугацаа, хүүгийн хэмжээг тохироогүй, захиран зарцуулах эрх нь шилжин ирээгүй түргэн борлогдох хөрөнгийг хасна;

- 4.4.4. Монголбанкнаас банк байгуулах зөвшөөрлийг нь хүчингүй болгосон, татан буугдсан, дампуурсан, банкны бүрэн эрхт төлөөлөгч, тусгай төлөөлөгч, эрх хүлээн авагч томилсон банкнаас авах авлагыг банк хоорондын захын цэвэр авлагын тооцоонд оруулахгүй;
- 4.4.5. Замд яваа мөнгийг түргэн борлогдох хөрөнгөөс хасна.
- 4.5. Нийт түргэн борлогдох хөрөнгөөс Банкны тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.3 дахь хэсгийн дагуу банкны нийт хадгаламжийн 0.3 хувьтай тэнцэх хөрөнгийг хасна.
- 4.6. Монголбанкны шалгалтаар илрүүлсэн зөрчил, дутагдалтай холбоотой залруулгын гүйлгээг зохих дансанд хийж түргэн борлогдох хөрөнгийн бодит дүнг гаргана.
- 4.7. Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг харилцах, хадгаламж, банк санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр, бусад өр төлбөр, арилжааны цэвэр өглөг, тэдгээрт хуримтлуулан тооцсон хүүгийн өглөг, биелэх нь тодорхой болсон хүлээж болох үүргийн дүнг нэмж тооцох бөгөөд дараах тохируулгыг гүйцэтгэнэ.
- 4.7.1. Клирингийн дамжуулалтын саатлын дансдын үлдэгдлийг хасна;
- 4.7.2. Банк хоорондын захаас татсан эх үүсвэрийг хасна;
- 4.7.3. Хоёрдогч өглөг, Хувьцаанд хөрвөх эх үүсвэрийг хасна.
- 4.8. Банк төлбөр түргэн гүйцэтгэх чадвартаа иж бүрэн үнэлгээ дүгнэлт өгч, нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зохистой харьцаа, эрсдэлийн удирдлагын зарчмыг дотооддоо мөрдөнө.
- 4.9. Банк орсон, гарсан мөнгөн урсгалын тайланг энэ журмын *** дугаар хавсралтын дагуу 7 хоног бүр тайлагнана.
- 4.10. Банк санхүүгийн байгууллагуудтай хийх тооцооны тайланг энэ журмын *** дугаар хавсралтын дагуу 7 хоног бүр тайлагнана.
- 4.11. Банк хугацаагаар ангилах боломжтой авлага, өглөгийн эргэн төлөгдөх үлдсэн хугацааны тайланг *** дугаар хавсралтын дагуу сар бүр тайлагнана.
- 4.12. Банк орох, гарах мөнгөн урсгалын төсөөллийг нэг сараар, төгрөг, валютаар гүйцэтгэж энэ журмын *** дугаар хавсралтын дагуу сар бүр тайлагнана.
- 4.13. Банк 100 том эх үүсвэрийн тайланг энэ журмын *** дугаар хавсралтын дагуу сар бүр тайлагнана.
- 4.14. Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварын эрсдэлийг үнэлэхэд шаардлагатай мэдээллийг тухай бүр хүргүүлнэ.

ТАВ. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЭРСДЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

- 5.1. Гадаад валютын ханшийн хэлбэлзлээс үүсч болзошгүй алдагдлыг банкны эрсдэл даах чадвартай уялдуулах зорилгоор тухайн нэг болон нийт гадаад валютын нээлттэй позицид хязгаарлалт тогтооно.
- 5.2. Тухайн нэг гадаад валютын нээлттэй позиц нь энэ журмын 2.10-д заасны дагуу тохируулсан 2.6-д тусгасан банкны өөрийн хөрөнгийн 15 хувиас хэтрэхгүй байна.
- 5.3. Нийт нээлттэй позицийг гадаад валют тус бүрийн хувьд тооцсон урт позицуудын

нийлбэр болон богино позицуудын абсолют нийлбэрийн аль их дүн дээр цэвэршүүлсэн алт, мөнгөний нээлттэй позицийн абсолют дүнг нэмж тодорхойлох бөгөөд энэ журмын 2.10-д заасны дагуу тохируулсан 2.6-д тусгасан банкны өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтрэхгүй байна.

- 5.4. Тухайн нэг банкны үйл ажиллагаа нь ханшийн зах зээлийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлж байна гэж үзвэл тус банкны зохистой харьцааны хязгаарын дээд хэмжээг бууруулж болно.
- 5.5. Нэг гадаад валютын нээлттэй позицийг дор дурдсанаар тооцно. Биелэлтийг энэ журмын *** дугаар хавсралтын дагуу долоо хоног болон сар бүр ирүүлнэ. Үүнд:
 - 5.5.1. Цэвэр спот позиц буюу тэнцлийн гадаад валютын актив, пассивын зөрүү (*үүнд хуримтлуулж тооцсон хүүг оруулан, цэвэршүүлсэн алт, мөнгөн гулдмайны үнэлгээг гаргахдаа тухайн үеийн спот ханшийг ашиглана, активын дүнгээс валютын эргэлзээтэй, муу зээлийн дүнг хасна*);
 - 5.5.2. Тэнцлийн гадуурхи гадаад валютын форвард, фьючерс болон свопын арилжаатай холбоотой өглөг авлагын зөрүү (*үүнд свопын хувьд спот арилжаатай холбоотой хэсгийг нь хасч тооцох бөгөөд ирээдүйд орох, гарах мөнгөн урсгалыг спот ханшаар нь үнэлнэ*);
 - 5.5.3. Гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу төлөх нь тодорхой болсон баталгаа, батлан даалт болон бусад тэнцлийн гадуур бүртгэлтэй хүлээж болзошгүй үүргийн сөрөг дүн;
 - 5.5.4. Ирээдүйд хэрэгжих нь тодорхой болсон, гэрээ, хэлцлээр баталгаажсан орлого, зарлагын гүйлгээний зөрүү;
 - 5.5.5. Энэ журмын *** дүгээр хавсралтын дагуу тооцсон гадаад валютын опционы "дельта" суурьтай өртөг;
- 5.6. Монголбанк биелэгдэх боломжгүй гэж үзсэн санхүүгийн үүсмэл хэлцлийн ирээдүйд үүсэх өглөг, авлагыг нээлттэй позицийн тооцоонд оруулахгүй үлдээх тохируулгыг гүйцэтгэж болно.
- 5.7. Нээлттэй позицын тооцоололд зөвхөн тайлант үеэс хойш 6 сарын дотор хэрэгжих гадаад валютын деривативууд, батлан даалт, аккредитивын орлого, зарлага болон гадаад валютын опционы дүнг тусгана. Үүнд Монголбанктай хийсэн хэлцэл хамаарахгүй.
- 5.8. Банк гадаад валютын ханшийн өөрчлөлтөөс хүлээж болзошгүй алдагдлыг тооцох аргачлалыг дотооддоо ашиглаж болно.

ЗУРГАА. ТӨВЛӨРЛИЙН ЭРСДЭЛИЙН ЗОХИСТОЙ ХАРЬЦАА

- 6.1. Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалтыг тооцох, хангах, тайлагнах, хяналт тавих журмын дагуу тодорхойлсон томоохон зээлдэгчдэд олгох активын нийлбэр өөрийн хөрөнгийн 300 хувиас хэтрэхгүй.
- 6.2. Банкны үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгийн нийлбэр нийт активын 8 хувиас хэтрэхгүй.
- 6.3. Банкны үйл ажиллагааг эрсдэлээс хамгаалах зорилгоор нийт зээл, активын харьцаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар хязгаарлалт тогтоож болно.

- 6.4. Банкны үйл ажиллагааны эрсдэлийн төвлөрлийг бууруулах зорилгоор нэг салбарын зээлийн нийт зээлд эзлэх хувьд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар хязгаарлалт тогтоож болно.
- 6.5. Банкны төвлөрлийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ энэ журмын 6.1-6.4 дахь хэсгээр хязгаарлагдахгүй.

НАЙМ. БУСАД

- 7.1. Банк энэ журамд тусгасан зохистой харьцааг өдөр бүр хангаж ажиллана. Энэ журмын хоёр, дөрөв, тавдугаар бүлэгт тусгасан зохистой харьцааг алдагдсан тохиолдолд Монголбанкинд бичгээр, банк хариуцсан хянан шалгагчид утсаар, цахим шудангаар тухай бүр мэдэгдэнэ.
- 7.2. Банк зохистой харьцааны биелэлтийн болон Монголбанкнаас шаардлагатай гэж үзсэн бусад тайланг дараа сарын 5-ны өдрийн дотор Монголбанкинд бичгээр болон цахим системээр ирүүлнэ.
- 7.3. Энэ журмын хэрэгжилтэд Монголбанк хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд банкинд холбогдох үүрэг, даалгавар өгөх, хууль, тогтоомжийн хүрээнд бусад арга хэмжээ авна.
- 7.4. Энэ журмыг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Банкны тухай хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага ногдуулна.

Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам 1 дүгээр хавсралт

**БАНКНЫ ӨӨРИЙН ХӨРӨНГИЙН ХҮРЭЛЦЭЭ
ТООЦОХ ХҮСНЭГТ**

	Үзүүлэлт	Amount
A	Өөрийн хөрөнгө /AI+AII/	
I	Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө (1+2+3+4+5-6)	0.0
1	Энгийн хувьцаа	
2	Энгийн хувьцаанд нэмэж төлөгдсөн капитал	
3	Хуримтлагдсан ашиг(алдагдал)	
4	Нөөц сан	
5	Тохируулга	
6	<i>Хасагдах (6.1+6.2+6.3)</i>	0.0
6.1	<i>Халаасны хувьцаа (Энгийн хувьцаа)</i>	
6.2	<i>Гүүдвэл, програм хангамж,</i>	
6.3	<i>Хойшлогдсон татварын авлага</i>	
II	Хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгө (1+2+3+4+5-6)	0.0
1	Давуу эрхийн хувьцаа	
2	Давуу эрхийн хувьцаанд нэмэж төлөгдсөн капитал	
3	Хувьцаанд хөрвөх эх үүсвэр	
4	Хоёрдогч өглөг	
5	Тохируулга	
6	<i>Халаасны хувьцаа (Давуу эрхийн хувьцаа)</i>	

	Үзүүлэлт	Risk weight
	Эрсдэлээр жигнэсэн актив (I+II+III+IV)	-
I	Тэнцлийн үзүүлэлт	-
	Бэлэн мөнгө	0%
	Замд яваа мөнгө	20%
	Төвбанкнаас авах авлага, түүнд хуримтлуулсан хүү	0%
	Дотоодын банкнаас авах авлага	-
	3 сараас доош хугацаатай, төгрөгийн авлага	20%
	Бусад	100%
	Хуримтлуулсан хүү	100%
	Хөгжлийн банкнаас авах авлага	-
	3 сараас доош, эвсэл 3 жилээс дээш хугацаатай, төгрөгийн авлага	20%
	Бусад	100%
	Хуримтлуулсан хүү	100%
	Хадгаламжийн даатгалын корпорациас авах авлага	0%
	Дотоодын бусад санхүүгийн байгууллагаас авах авлага	100%
	Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авах авлага	-
	20%-иар жигнэгдэх	20%
	50%-иар жигнэгдэх	50%
	100%-иар жигнэгдэх	100%
	150%-иар жигнэгдэх	150%
	Төвбанкны үнэт цаас, хуримтлуулж тооцсон хүү	0%
	Засгийн газрын үнэт цаас	-
	Засгийн газрын үнэт цаас, хуримтлуулж тооцсон хүү	0%
	Засгийн газрын баталгаатай үнэт цаас	0%
	Засгийн газрын баталгаатай үнэт цаасны хуримтлуулж тооцсон хүү	100%
	Дотоодын үнэт цаас	-
	Хувьцаа, вексель, бусад	100%
	Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	-
	Нэхэмжлэх эрх нь ялгаагүй хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	100%
	Нэхэмжлэх эрх нь ялгаатай хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас	-
	Хамгийн давуу эрхтэй хэсэг	100%
	Бусад хэсэг	200%
	МИК-ээс гаргасан ИЗЗБ	50%

	Бусад үнэт цаас	100%
	Хуримтлуулж тооцсон хүү	100%
	Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авах авлага	-
	20%-иар жигнэгдэх	20%
	50%-иар жигнэгдэх	50%
	100%-иар жигнэгдэх	100%
	150%-иар жигнэгдэх	150%
	Хараат болон охин компанид оруулсан хөрөнгө оруулалт	100%
	Зээд	-
	Гадаадын банк, санхүүгийн байгууллагуудаас авах авлага	-
	20%-иар жигнэгдэх	20%
	50%-иар жигнэгдэх	50%
	100%-иар жигнэгдэх	100%
	150%-иар жигнэгдэх	150%
	Ипотекийн зээл	50%
	Ханшийн эрсдэлтэй иргэн, хуулийн этгээдэд олгосон зээл	150%
	Бусад зээл	100%
	Чанаргүй зээд	150%
	Зээлд хуримтлагдсан хүү	100%
	Санхүүгийн хөрөнгө, хуримтлагдсан хүү	100%
	Санхүүгийн бус хөрөнгө	-
	Алт, мөнгөн гулдмай	0%
	Буса санхүүгийн бус хөрөнгө	100%
	Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгө	100%
	Дериватив санхүүгийн хөрөнгө	-
	Монголбанктай хийсэн дериватив хэлцэл	0%
	Бусад	100%
II	Тэнцлийн гадуурх үзүүлэлт	
1	Деривативын зээлтэй адилтган тооцох өртөг	100%
2	Аккредитивууд	20%
3	Батлан даалт, баталгаа	100%
4	Тендер болон гүйцэтгэлийн батлан даалт	50%
5	Зээлийн шугам	50%
6	Хамтын санхүүжилттэй зээлийн эрсдэлд харгалзах зээлийн цэвэр үлдэгдэл	100%
7	Бусад хүлээж болох үүрэг	50%
III	Гадаад валютын эрсдлийн үзүүлэлт	xxxxxx
IV	Сүүлийн гурван жилийн эерэг ний орлогын дундаж	xxxxxx

БУСАД ХАВСРАЛТЫГ ТУСАД НЬ БАНКУУДАД ТАНИЛЦУУЛАХ БОЛНО.